



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 5/203

Улаанбаатар хот

С.Ганбаатарыг ажлаас чөлөөлж, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.7, 271¹.1.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Хэвлэл мэдээлэл, сургалт судалгааны төвийн багш- гаалийн улсын байцаагч Санжавын Ганбаатарыг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.С.Ганбаатарт төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 32,320,900 /гучин хоёр сая гурван зуун хорин мянга есөн зуу/ төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3.Ажлаас чөлөөлөгдөж байгаа С.Ганбаатарын гаалийн улсын байцаагчийн хувийн дугаар бүхий тэмдэг, ялгах тэмдгийг хүлээн авч, холбогдох тооцоог зохих журмын дагуу хийхийг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/, Хэвлэл мэдээлэл, сургалт судалгааны төв /П.Дорждагва/-д тус тус даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ

1439501 0399